



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/75.

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "н", Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батноров сумын нутаг дэвсгэрт байгалийн өнгөт чулуу хууль бусаар олборлож хууль зөрчсөн үйлдлийг таслан зогсоож ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Сүнгээ	-Мэргэжлийн хяналтын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Ц.Баярхүү	-Цагдаагийн газрын дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа
Гишүүдэд:	Б.Дархантөр	-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
	Ц.Лхадорж	-Тагнуулын хэлтсийн ажилтан, хошууч
	Ж.Отгонбаяр	-Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, Цагдаагийн дэд хурандаа
	Д.Баасандорж	-Батноров сум дахь цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн хошууч

2. Хууль бусаар өнгөт чулуу олборлож хууль зөрчсөн үйлдлийг таслан зогсоох ажлыг удирдамжийн дагуу зохион байгуулж арга хэмжээний явц, үр дүнг аймгийн удирдлагуудад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч Мэргэжлийн хяналтын газрын дарга /Б.Сүнгээ/-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Л.Бат-Октябрь/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА